



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын ерөнхий боловсролын гуравдугаар сургуулийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2026/67/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.open.audit.mn Архангай аймаг 2026 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn Аудитыг гүйцэтгэсэн: Гроут финанс Аудит ХХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Бямбадорж Утас: 77721628 Цахим хаяг: Byambadorj@growthfinance.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2026.02.24 № 53

танай _____-ны № _____-т

АРХАНГАЙ АЙМГИЙН ЭРДЭНЭБУЛГАН
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
3 ДУГААР СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Б.ЭНХБОЛД ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Эрдэнэбулган сумын ерөнхий боловсролын гуравдугаар сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудал

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх “Ерөнхий боловсрол” хөтөлбөрийн хүрээнд үндсэн үйл ажиллагааны 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр 4,746,963.2 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлж, гүйцэтгэлээр 4,698,316.1 мянган төгрөг зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 16 үндсэн зорилтын хүрээнд 38 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөгөөр)

Дансны код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	508,628,661.83	294,980,918.50
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	255,375,325.40	41,627,921.97
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	255,375,325.40	41,627,921.97
3121	Төгрөг	255,375,325.40	41,627,921.97
31211	Төрийн сангийн харилцах	255,375,325.40	41,627,921.97
35	БАРАА МАТЕРИАЛ	253,253,336.43	253,352,996.53
351	Түүхий эд материал	1,171,000.00	1,497,775.50
35130	Эм боох материал	1,171,000.00	1,497,775.50
354	Хангамжийн материал	252,082,336.43	251,855,221.03
35420	Аж ахуйн материал	184,173,953.03	187,297,046.03
35440	Түлш, шатах тослох материал	0.00	1,600,000.00
35450	Барилгын засварын материал	29,629,873.00	36,299,873.00
35470	Бусад хангамжийн материал	38,278,510.40	26,658,302.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,984,260,096.14	6,469,717,465.77
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,984,260,096.14	6,469,717,465.77
392	Биет хөрөнгө	2,774,561,345.99	6,256,657,703.45
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,688,542,495.49	6,167,323,087.49
39202	Хуримтлагдсан элэгдэл	(656,422,492.88)	(759,085,635.48)
39203	Авто тээврийн хэрэгсэл	1,910,000.00	0.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(1,910,000.00)	0.00
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	540,042,538.76	587,574,600.92
39206	Хуримтлагдсан элэгдэл	(158,608,675.11)	(202,862,503.51)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	243,986,551.09	332,384,114.74
39208	Хуримтлагдсан элэгдэл	(84,669,542.00)	(73,567,898.12)
39214	Бусад үндсэн хөрөнгө	149,880,000.00	149,880,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(22,380,000.20)	(31,546,666.88)
39217	Ном	74,190,470.84	86,558,604.29
393	Биет бус хөрөнгө	209,698,750.15	213,059,762.32
39301	Програм хангамж	8,162,798.00	11,207,678.80
39302	Хасагдуулга	(2,094,047.85)	(1,777,916.48)
39303	Бусад биет бус хөрөнгө	203,630,000.00	203,630,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,492,888,757.97	6,764,698,384.27
4	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	0.00	38,530,877.91
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	38,530,877.91
413	Өглөг	0.00	23,672,862.91
41310	Ажиллагчидтай холбогдсон өглөг	0.00	180,728.91
41320	Хоолны өглөг	0.00	5,711,234.00
41321	Урсгал засварын өглөг	0.00	17,780,900.00
4136	Бусад өглөг	0.00	14,858,015.00
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	14,858,015.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,492,888,757.97	6,726,167,506.36
51	Засгийн газрын хувь оролцоо	3,492,888,757.97	6,726,167,506.36
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,040,869,958.41	1,040,869,958.41

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын ерөнхий боловсролын гуравдугаар сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

51101	Өмч: - төрийн	1,040,869,958.41	1,040,869,958.41
512	Хуримтлагдсан үр дүн	1,041,884,160.06	4,288,211,428.45
51210	Өмнөх үеийн үр дүн	1,041,884,160.06	1,054,932,680.06
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	3,233,278,748.39
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,410,134,639.50	1,397,086,119.50
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,492,888,757.97	6,764,698,384.27

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөгөөр)

Дансны код	Балансын зүйл	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,407,397,121.70	8,163,338,441.92
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	361,444,521.70	3,703,870,941.92
120	Нийтлэг татварын бус орлого	361,444,521.70	3,703,870,941.92
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	9,175,600.00	25,101,200.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,974,300.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,201,300.00	25,101,200.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- үндсэн хөрөнгө	326,734,356.40	3,672,673,401.32
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого – Бараа материал	25,534,565.30	6,096,340.60
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,045,952,600.00	4,459,467,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,612,162,400.00	4,070,602,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,612,162,400.00	4,070,602,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	433,790,200.00	388,865,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	433,790,200.00	388,865,300.00
1330	Төсвийн захирагчдаас	-	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	4,083,514,630.87	4,904,640,349.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,083,514,630.87	4,904,640,349.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,855,628,878.57	4,585,359,649.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,765,535,881.05	3,306,946,889.34
210101	Цалин	1,732,592,710.05	2,037,443,749.98
210102	Нэмэгдэл цалин	855,434,961.00	990,708,659.36
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	97,600,000.00
210104	Урамшуулал	177,508,210.00	181,194,480.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	346,356,942.28	411,169,390.75
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	239,126,215.95	283,380,379.76
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	28,005,607.87	33,381,883.99
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	14,391,166.12	17,274,164.39
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	12,965,136.09	15,656,367.17
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	51,868,816.25	61,476,595.44
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	357,063,237.70	385,576,534.00
210301	Гэрэл цахилгааны зардал	21,319,827.00	18,771,415.00
210302	Түлш, халаалтын зардал	260,113,816.00	288,614,565.82
210303	Цэвэр, бохир усны зардал	75,629,594.70	78,190,553.18
2104	Хангамж, бараа материалын зардал	3,100,000.00	21,598,076.00
210402	Тээвэр, шатахууны зардал	3,100,000.00	-
210408	Бараа материал акталсны зардал	-	21,598,076.00
2105	Нормативт зардал	607,000.00	-
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	607,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,712,450.00	20,110,900.00
210604	Урсгал засвар	20,712,450.00	20,110,900.00
2107	Томиллолт, зочны зардал	-	-

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын ерөнхий боловсролын гуравдугаар сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	26,232,193.80	71,428,817.23
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,961,500.00	24,856,200.00
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	-	1,800,000.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	24,270,693.80	44,772,617.23
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	336,021,173.74	368,529,041.78
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	84,151,219.00	76,468,239.52
210902	Хичээл үйлвэрлэлийн дадлага хийх	30,164,536.00	35,429,115.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	221,705,418.74	256,631,687.26
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	227,885,752.30	319,280,700.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	221,158,790.00	319,280,700.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	186,930,490.00	286,741,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	34,228,300.00	32,538,800.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	6,726,962.30	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,726,962.30	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	323,882,490.83	3,258,698,092.82
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	3,697,727.95	25,419,344.43
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	3,697,727.95	25,419,344.43
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(3,697,727.95)	(25,419,344.43)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	320,184,762.88	3,233,278,748.39

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	4,055,128,200.00	4,484,568,700.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,175,600.00	25,101,200.00
120	Нийтлэг татварын бус орлого	9,175,600.00	25,101,200.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,175,600.00	25,101,200.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,974,300.00	25,101,200.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,201,300.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,045,952,600.00	4,459,467,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,612,162,400.00	4,070,602,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,612,162,400.00	4,070,602,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	433,790,200.00	388,865,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	433,790,200.00	388,865,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	3,872,251,292.13	4,603,481,103.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,872,251,292.13	4,603,481,103.43
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,645,289,539.83	4,284,200,403.43
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	2,771,921,395.31	3,308,779,689.92
210101	Үндсэн цалин	1,719,186,287.05	2,056,801,063.90
210102	Нэмэгдэл	872,604,580.00	973,854,360.65
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	-	97,035,627.37
210104	Урамшуулал	180,130,528.26	181,088,638.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	339,971,428.02	409,155,861.26
210201	Тэтгэврийн даатгал	232,180,321.90	279,039,763.34
210202	Тэтгэмжийн даатгал	27,263,587.08	33,150,120.94
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,783,597.82	16,947,412.46
210204	Ажилгүйдлийн даатгал	13,342,958.74	16,003,773.88
210205	Эрүүл мэндийн даатгал	53,400,962.48	64,014,790.64
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	357,063,237.70	379,865,300.00
210301	Гэрэл, цахилгаан	20,091,186.00	18,771,415.00
210302	Түлш, халаалт	260,113,816.00	296,686,287.82
210303	Цэвэр, бохир ус	76,858,235.70	64,407,597.18
2104	Хангамж, бараа материалын зардал	-	-
2105	Нормативт зардал	-	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,000,000.00	9,000,000.00

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын ерөнхий боловсролын гуравдугаар сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210604	Урсгал засвар	15,000,000.00	9,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	39,436,812.80	85,291,471.75
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,884,100.00	24,856,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	34,552,712.80	60,435,271.75
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	121,896,666.00	92,108,080.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	91,499,976.00	69,360,380.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	30,396,690.00	22,747,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	226,961,752.30	319,280,700.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	220,234,790.00	319,280,700.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	186,006,490.00	286,741,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	34,228,300.00	32,538,800.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,726,962.30	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	6,726,962.30	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг -Орон нутгийн төсөв	6,726,962.30	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	182,876,907.87	(118,912,403.43)
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	180,408,039.00	94,835,000.00
	Дотоод эх үүсвэрээр	180,408,039.00	94,835,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	180,408,039.00	94,835,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(180,408,039.00)	(94,835,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	2,468,868.87	(213,747,403.43)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	252,906,456.53	255,375,325.40
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	255,375,325.40	41,627,921.97

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
4-01	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,040,869,958.41	1,410,134,639.50	721,699,397.18	3,172,703,995.09
4-03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,040,869,958.41	1,410,134,639.50	721,699,397.18	3,172,703,995.09
4-08	Тайлант үеийн үр дүн	-	-	320,184,762.88	320,184,762.88
4-01	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,040,869,958.41	1,410,134,639.50	1,041,884,160.06	3,492,888,757.97
4-03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,040,869,958.41	1,410,134,639.50	1,041,884,160.06	3,492,888,757.97
4-04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(13,048,520.00)	13,048,520.00	-
4-08	Тайлант үеийн үр дүн	-	-	3,233,278,748.39	3,233,278,748.39
4-01	2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,040,869,958.41	1,397,086,119.50	4,288,211,428.45	6,726,167,506.36

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Бүртгэлийн дансны код	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		4,745,208,200.00	4,698,316,103.43	46,892,096.57	99.01
УРСГАЛ ЗАРДАЛ		4,745,208,200.00	4,698,316,103.43	46,892,096.57	99.01
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		4,415,047,900.00	4,379,035,403.43	36,012,496.57	99.18

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын ерөнхий боловсролын гуравдугаар сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	2101	3,322,243,900.00	3,308,779,689.92	13,464,210.08	99.59
Үндсэн цалин	210101	2,168,321,100.00	2,056,801,063.90	111,520,036.10	94.86
Нэмэгдэл	210102	1,020,072,600.00	973,854,360.65	46,218,239.35	95.47
Унаа хоолны Хөнгөлөлт	210103	-	97,035,627.37	(97,035,627.37)	-
Урамшуулал	210104	133,850,200.00	181,088,638.00	(47,238,438.00)	135.29
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2102	415,499,100.00	409,155,861.26	6,343,238.74	98.47
Тэтгэврийн даатгал	210201	282,539,400.00	279,039,763.34	3,499,636.66	98.76
Тэтгэмжийн даатгал	210202	33,240,000.00	33,150,120.94	89,879.06	99.73
ҮОМШӨ-ний даатгал	210203	16,619,900.00	16,947,412.46	(327,512.46)	101.97
Ажилгүйдлийн даатгал	210204	16,619,900.00	16,003,773.88	616,126.12	96.29
Эрүүл мэндийн даатгал	210205	66,479,900.00	64,014,790.64	2,465,109.36	96.29
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2103	379,865,300.00	379,865,300.00	0.00	100.00
Гэрэл, цахилгаан	210301	30,000,000.00	18,771,415.00	11,228,585.00	62.57
Түлш, халаалт	210302	294,717,300.00	296,686,287.82	(1,968,987.82)	100.67
Цэвэр, бохир ус	210303	55,148,000.00	64,407,597.18	(9,259,597.18)	116.79
Хангамж, бараа материалын зардал	2104	-	-	-	-
Нормативт зардал	2105	-	-	-	-
Эд хогшил, урсгал засварын зардал	2106	9,000,000.00	9,000,000.00	-	100.00
Урсгал засвар	210604	9,000,000.00	9,000,000.00	-	100.00
Томилолт, зочны зардал	2107	-	-	-	-
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2108	102,227,100.00	89,091,471.75	13,135,628.25	87.15
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	210801	24,856,200.00	24,856,200.00	-	100.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	210806	77,370,900.00	64,235,271.75	13,135,628.25	83.02
Бараа үйлчилгээний бусад зардал	2109	186,212,500.00	183,143,080.50	3,069,419.50	98.35
Бараа үйлчилгээний бусад зардал	210901	163,464,800.00	160,395,380.50	3,069,419.50	98.12
Хичээл үйлдвэрлэлийн дадлага	210902	22,747,700.00	22,747,700.00	-	100.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		330,160,300.00	319,280,700.00	10,879,600.00	96.70
Засгийн газрын урсгал шилжүүлэг		-	-	-	-
Бусад урсгал шилжүүлэг	213	330,160,300.00	319,280,700.00	10,879,600.00	96.70
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	213205	297,621,500.00	286,741,900.00	10,879,600.00	96.34
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	213209	32,538,800.00	32,538,800.00	-	100.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		4,746,963,200.00	4,484,568,700.00	262,639,500.00	94.47
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	131	4,333,241,700.00	4,070,602,200.00	262,639,500.00	93.94
Улсын төсвөөс санхүүжих	131001	4,077,956,800.00	4,070,602,200.00	7,354,600.00	99.82
Оны эхний үлдэгдлээс санхүүжих	131009	255,284,900.00	-	255,284,900.00	-
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ		388,865,300.00	388,865,300.00	-	100.00

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын ерөнхий боловсролын гуравдугаар сургуулийн 2025 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Орон нутгийн төсвөөс	132001	388,865,300.00	388,865,300.00	-	100.00
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС		24,856,200.00	25,101,200.00	-	100.99
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1200041	24,856,200.00	25,101,200.00	(245,000.00)	100.99
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		255,375,325.40	255,375,325.40	-	100.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		257,130,325.40	41,627,921.97	215,747,403.43	16.19
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ					
БАЙГУУЛЛАГЫН ТОО		1.00	1.00	-	100.0
Төсвийн байгууллага		1.00	1.00	-	100.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО		108.00	106.00	2.00	98.10
Удирдах ажилтан		4.00	4.00	-	100.0
Гүйцэтгэх ажилтан		80.00	78.00	2.00	97.5
Үйлчлэх ажилтан		24.00	24.00	-	100.0
СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)		1,738.00	1,730.00	8.00	99.5
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД		1,738.00	1,730.00	8.00	99.5

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа илрээгүй тул залруулга хийгээгүй.

Аудитаар залруулаагүй 6,361.6 мянган төгрөгийн зөрчил¹ илэрч 3,697.6 мянган төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт, 2,664.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүллээ.

Аудитаар залруулагдаагүй 4 зөрчилтэй асуудлын материаллаг алдаа зөрчил нь 6,361.6 мянган төгрөг бөгөөд гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 50,327.4 мянган төгрөгөөс бага байх тул **Өөрчлөлтгүй дүгнэлт** өглөө.

3.1 Төлбөрийн акт

3.1.1. Нэр бүхий 6 ажилтанд 2,144.0 мянган төгрөгийн цалинг ажлаагүй хугацаанд нь олгосон. Энэ нь цагийн бүртгэл буруу, цагийн бүртгэлээс зөрүүтэйгээр цалин бодсонтой холбоотой байна;

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.3 "гүйцэтгэсэн ажил үүрэгтээ тохирсон цалин хөлс авах" мөн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэсэн заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.1.2. Нэр бүхий 7 ажилтанд холбогдох журам зөрчин 882.0 мянган төгрөгийн илүү цагийн нэмэгдлийг олгосон.

Энэ нь ЗГ-ын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ын Хоёр "Нэмэгдэл хөлс тооцох аргачлал"-ын 3 "Илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс тооцох цаг нь 4.1-т зааснаас бусад тохиолдолд тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрэхгүй байна. Тухайлбал, 8 дугаар сарын ажлын цаг 160 гэж үзвэл тухайн сард нэмэгдэл хөлс тооцогдох цаг нь 16-аас илүүгүй байна." гэсэн заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.1.3. Цалингийн системд ажилтнуудын ур чадвар, улирлын нэмэгдлийн хувийг тушаал шийдвэрээс зөрүүтэй оруулснаас нэр бүхий 3 ажилтанд 671.5 мянган төгрөгийн нэмэгдэл цалин илүү тооцон олгожээ..

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.6 "харьяа дээд шатны албан тушаалтны зөвхөн хуульд нийцсэн шийдвэрийг биелүүлэх", "ЗГ-ын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт "Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам"-ын 2 "Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг тухайн байгууллагын төсвийн шууд захирагч шийдвэрлэнэ" гэсэн заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.2 Албан шаардлага

3.2.1. "Балансын урамшуулал олгох тухай" Архангай аймгийн Боловсролын газрын даргын 2025.09.03-ны өдрийн А/38 дугаар тушаал, тус сургуулийн захирлын 2025.09.18-ны өдрийн Б/104 дүгээр тушаалуудыг үндэслэн "2024 санхүүгийн тайланд өөрчлөлтгүй дүгнэлт авсан гэсэн үндэслэлээр нягтлан бодогчид 1,559.0 мянган төгрөгийн, няравт 1,105.0 мянган төгрөг

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

нийт "балансын урамшуулал" 2,664.0 мянган төгрөгийг "улирлын үр дүнгийн урамшуулал"-тай давхардуулан олгосон нь хууль, журамд нийцэхгүй байна.

Энэ нь "Төрийн хэмнэлтийн тухай" хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно": 15.1.3 "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", "Төрийн албаны тухай" хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.Онцгой чухал буюу онц түвэгтэй албан даалгавар биелүүлсэн, байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулалт, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн болон бусад нөхцөл, шаардлагыг хангасан төрийн албан хаагчийг дараахь хэлбэрээр шагнаж, урамшуулна: 51.1.4 "улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ажлаагүй үед цалин олгосон	1	2,144.0	1	2,144.0				
Илүү цагийн нэмэгдэл илүү тооцож олгосон	1	882.0	1	882.0				
Ур чадварын нэмэгдэл болон улирлын урамшуулал илүү тооцож олгосон	1	671.6	1	671.6				
Балансын урамшуулал олгосон	1	2,664.0			1	2,664.0		
Дүн	4	6,361.6	3	3,697.6	1	2,664.0	-	-